

Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын тэмдэглэл

2022.04.29

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал, товлосон зарын дагуу 2022.04.29-ний өдрийн 14 цагт Компанийн Хурлын танхимаас цахимаар шууд дамжуулан явууллаа.

Хурлын дэгийн дагуу Тооллогын Комиссын дарга И.Галтхүү “Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай” №1 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Тооллогын Комиссын дарга И.Галтхүү: Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 3800721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9902 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 2 905745 ширхэг хувьцаа эзэмшсэн 87 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 76, 4 хувь байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн “Хурал хурал хүчин төгөлдөрт тооцсугай” гэв.

Үүний дараа Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг Компанийн Гүйцэтгэх захирал, аж үйлдвэрийн гавьяат ажилтан Г.Бүдрагчаа хурлыг нээж үг хэлэв. Г.Бүдрагчаа: Энэ удаагийн хурлыг цахимаар зохион байгуулж байна. Хувьцаа эзэмшигч та бүхнийг компанийн пэйж хуудсанд хандан цахимаар хурлыг сонирхож үзэх, санал хүсэлтээ явуулах боломжтойг хэллээ. Ингээд хурлын дэгийг уншиж танилцуулан хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг ажилдаа орхыг урив.

Хурал дараглагч: Өнөөдөр хурлаар:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-аас өгөөн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
2. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөшөөг батлах
3. ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох, 2022 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцнэ гэсний дагуу хурлыг дараах ёсоор:
 1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг компанийн борлуулалтын албаны дарга Н.Алтан-Эрдэнэ илтгэв.
 2. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ерөнхий инженер Н.Маралсүрэн тайлагнав.
 3. Компанийн 2021 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан С.Мөнхжаргал тайлагнав.
 4. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн товч намтарыг болон ТУЗ-ийн 2022 оны төсөвийг 12840000 төгрөгөөр батлуулахаар санал оруулав.
 5. “Ногдол ашиг хуваарилах” тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав. Үүний дараа Хувьцаа Эзэмшигчдээс ирсэн асуултыг танилцуулж холбогдох албан тушаалтангууд хариулт өгөв.

Асуулт: Ногдол ашгийг хэзээ өгөх вэ? Өмнө онуудын аваагүй ногдол ашгийг авч болох уу?

Ерөнхий нябо С.Мөнхжаргал: 2021 оны ногдол ашгийг 2022.10.01 ний өдрөөс эхлэн олгоно. Аваагүй оныхыг нөхөн олгоно.

Асуулт: УБ хот руу амьд мал оруулахгүй шийдвэр гараад удаж байна. Та бүхэн цаашдын үйл ажиллагаагаа яаж явуулах вэ?

Хариулт: УБ хот руу амьд мал оруулахгүй байгаа тул бид өөрсдөө өөрийн унаагаар амьд малаа оруулж байна. Бид 2022 онд баруун, зүүн бүсэд мах боловсруулах үйлдвэр барихаар төлөвлөсөн. Ингэснээр уг бэрхшээл арилах болно.

Асуулт: Олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хэзээнээс хэрэгжүүлж эхлэх вэ? Барилга байгууламжууд хэзээ баригдах вэ?

Хариулт: Барилгын шинэчлэл хийгдэж эхэлсэн. 1962 онд баригдсан барилгыг нураах, үйлдвэрийн болон ажилчдын цайны газрын суурин дээр 7000 кв талбайд шинэ ложистикын төв баригдана. Одоогоор “Техник технологийн проект боловсруулах гэрээнд гарын үсэг зурсан. Гэрээний дагуу Технологийн проектийг иж бүрнээр нь хүлээн авах, техникийн проектыг үргэлжлүүлэн хийж байна.

Асуулт: Махны үнэ өсөх үү?

Г.Бүдрагчаа: 2022 оны 7-р сарын 1-ны өдөр хүртэл үнэ өсөхгүй. Цаашид мах бэлтгэлээс шалтгаалан тухай үед өөрчлөгдөнө. Одоогоор жижиглэнгийн үнэ хонь-7950₮, үхэр-8900₮, ямаа-7000₮ байна. Хонины махны үнэ 250₮-өөр буурсан байна.

Асуулт: Нөөцийн махны борлуулалт хаагуур хийгдэж байна вэ?

Хариулт: Борлуулалтын албаны дарга Н.Алтан-Эрдэнэ: Улаанбаатар хотын захирагчийн албаны даргын баталсан цэг, байршилд борлуулалт хийгдэж байна. БГД, СХД, БЗДүүргүүдэд нөөцийн махны өргөтгөсөн худалдаа хийгдэж байна.

Асуулт: Яагаад экспорт хийхгүй байна вэ?

Хариулт: Г.Бүдрагчаа: Цар тахлын 2021 оны 6-р сараас эхлэн экспорт бүрэн зогссон. Засгийн газраас БНХАУ-тай удаа дараалан хуралдсаны үндсэн дээр махны экспортыг сэргээж эхлүүлэх талаар яригдаж байна. Энэ оны 5-р сараас дулааны аргаар бэлтгэсэн махыг экспортолж эхлэхээр яригдаж байна.

Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй тул санал хүсэлтийг тасалж байна. Та бүхний саналыг бид сонслоо, тэмдэглэл тусгаж байгаа болно. Цаашдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга И.Галтхүү: “Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах” тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Компанийн нийт 3800721 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9902 хувьцаа эзэмшигчдээс хуралд 2905745 ширхэг хувьцаа эзэмшсэн 87 хувьцаа эзэмшигч оролцов.

Тооллогын Комиссоос тараасан саналын хуудас 87 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр нь хүчинтэй саналын тоо 75 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын тоо 12 байна.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн 2905745 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100% татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
2. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 2905745ш хувьцаа буюу нийт саналын 100% тутгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
3. Компанийн ТУЗ-ийн 2022 оны зардлын төсөвийг 12840000₮-өөр батлахыг зөвшөөрсөн 2905745 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100%, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
4. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр
 - Б.Оргилболдыг сонгохыг зөвшөөрсөн 2903771 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,93%
 - Г.Цэнгүүнийг сонгохыг зөвшөөрсөн 2902787 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,89% байгааг үндэслэн Баттуул овогтой Оргилболд, Ганбат овогтой Цэнгүүн нарыг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгуулахаар.
5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр тогтоосоныг зөвшөөрсөн 2900385 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9% татгалзсан 2903 ширхэг буюу нийт саналын 0,1% түдгэлзсэн санал байхгүйг үндэслэн ТОГТООХ НЬ:
 1. Дээрхи хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай. Тооллогын комиссын дарга И.Галтхүү, гишүүд гэж уншиж танилцуулав.

Хурлын дарга Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас №1 тоот тогтоол гарч байгааг уншиж танилцууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
Үүнд:
 - 2.1 Компанийн борлуулалтыг дэмжих зорилгоор “МИК-80” хөтөлбөрийг батлах;
 - 2.2 Компанийн хөргөлттэй агуулахыг шинэчлэх, технологи болон техникийн төсөл хийлгэх ажлыг дэмжих;
 - 2.3 Компанийн дэд бүтцийг шинэчлэх зорилгоор хөрөнгө оруулалтын төсөв баталж мөрдөх;
 - 2.4 Компанийн хашаанд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй менежмент, үйл ажиллагаа, болон сервитутын гэрээг шинэчлэн байгуулах;
 - 2.5 Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, 1962 онд баригдсан автопарк, механик цехийг актлан, газрыг шилжүүлэн, шинээр үйлдвэр байгуулахыг зөвшөөрсүгэй;

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг 12,840,000 /арван хоёр сая найман зуун дөчин мянга/ төгрөгөөр баталсугай.
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр Баттуул овогтой Оргилболд, Ганбат овогтой Цэнгүүн нарыг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.
5. Нэгж хувыцаанд оногдох ногдол ашгийг 100 /нэг зуу/ төгрөгөөр тогтоосугай.

Хурлын дарга
Тэмдэглэсэн

Г.Бүдрагчаа
И.Өлзийбаяр